



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХЭА-2022/04/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Чингис хот

2022 он

Тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар

Утас: 70562112 Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Аудитын менежер: Д.Оюунтуяа

Утас: 99775390

Ахлах аудитор: Н.Туяа

Утас: 99799709

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг [khentii@audit.gov.mn](mailto:khentii@audit.gov.mn) хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт .....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	3
3. Аудитын тайлан .....	4
3.1 Ерөнхий зүйл .....	4
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	4
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	5
3.4 Материаллаг байдал .....	5
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	5
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	5
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	7
3.8 Аудитын гол асуудал .....	7
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	7
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	7
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	7
4. Аудитын илрүүлэлт .....	8
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	9

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



## ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг

Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12

E-mail: [khentii@audit.gov.mn](mailto:khentii@audit.gov.mn)

᠒᠐᠒᠒.᠐᠒.᠒᠒ № 1᠒

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Прокурорын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Прокурорын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭРДЭНЭБААТАР

023030005

## **2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**

---

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

**2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлтийн тайлан**

**2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

---

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хэнтий аймгийн Прокурорын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Н.Туяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа, дарга, тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хэнтий аймгийн Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 183 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Прокурорын тухай хуульд Прокурорын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Прокурорын байгууллага Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн болон зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцох чиг үүрэг бүхий, хараат бус, бие даасан шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцогч байгууллага мөн.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Улсын Ерөнхий прокурорын газрын Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас 2021 онд аймгийн Прокурорын газрын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хэнтий аймгийн Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр өмнөх оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 75 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 482,044.5 сая төгрөгөөс 1 хувиар буюу 4.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 3.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Аймгийн Прокурорын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 64,338.8 мянган төгрөгөөр буюу 15.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, хуримтлагдсан үр дүн данснууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	
Авлага	-		-
Урьдчилгаа			-
Бараа материал	13,159.1	40,096.3	26,937.2
Үндсэн хөрөнгө	393,582.6	430,984.2	37,401.6
<b>Нийт хөрөнгө</b>	<b>406,741.7</b>	<b>471,080.5</b>	<b>64,338.8</b>
Өр төлбөр			-
Засгийн газрын оруулсан капитал	307,601.9	307,601.9	-
Хуримтлагдсан үр дүн	(92,993.5)	(28,434.7)	64,558.8
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	191,913.3	191,693.3	(220.0)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>406,521.7</b>	<b>470,860.5</b>	<b>64,338.8</b>

Бараа материалын дансны үлдэгдэл 40,096.3 мянган төгрөг болж 26,937.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд 55,842.4 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 48,155.5 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, малын нас дэвшилтийн орлого болон бараа материалыг шилжүүлэн авснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 430,984.2 мянган төгрөг болж 37,401.6 мянган төгрөгөөр өссөн нь 64,520.9 мянган төгрөгийн хөрөнгийг худалдан авч, 15,414.0 мянган төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассантай холбоотой байна.

Хуримтлагдсан үр дүн дансны үлдэгдэл (28,434.7) мянган төгрөг болж 64,558.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацааны үр дүнгийн өсөлт нөлөөлжээ.

Дахин үнэлгээний зөрүү данс 220.0 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийг данснаас хассантай холбоотой байна.

Аймгийн Прокурорын газрын 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 260,681.6 мянган төгрөгөөр буюу 53.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь урсгал үйл ажиллагааны санхүүжилт 228,281.4 мянган төгрөгөөр, төсөвт байгууллагын өөрийн орлого 32,400.2 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ.

Нийт зардал өмнөх оноос 208,324.1 мянган төгрөгөөр буюу 43.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлуудыг авч үзвэл цалин хөлсний зардал 139,960. мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 17,689.8 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал 10,086.9 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 19,124.3 мянган төгрөгөөр, төвлөрүүлэх шилжүүлгийн зардал 17,691.4 мянган төгрөгөөр өссөн байна. Зардлын өсөлтөд тайлант оноос албан хаагчдад үр дүнгийн урамшуулал олгож эхэлсэн, албан тушаалтнуудын зэрэг дэв нэмэгдсэн, ковидтой холбоотой зардал гарсан нь голлон нөлөөлсөн байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тухайн байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 570,643.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 125,951.3 мянган төгрөгөөр өсгөн 696,594.3 мянган төгрөгөөр баталсан нь үндсэн цалин, нийгмийн даатгалын шимтгэл болон бараа үйлчилгээний бусад зардлуудыг нэмсэнтэй холбоотой байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлэхээр 696,594.3 мянган төгрөгийн төсөв батлагджээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 696,594.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 673,282.8 мянган төгрөг зарцуулж, 23,311.5 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлж, төсвийн нийт зардлын гүйцэтгэл 96.7 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансаар орлого, зарлагын гүйлгээ хийгдээгүй байна. Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Асуудлыг онцолсон хэсэг болон бусад асуудлын хэсэгт хамааралтай асуудал байхгүй.

### **3.8 Аудитын гол асуудал**

Аудитаар илэрсэн гол асуудал байхгүй.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд нийт мэдээлбэл зохих 786.9 сая төгрөгийн 52 мэдээллийг бүрэн мэдээлсэн байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн асуудалд өгсөн 1 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарах асуудал илрээгүй.

#### **4. Аудитын илрүүлэлт**

---

Аудитаар алдаа зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Аймгийн Прокурорын газар	0	0	0	0	0	0	0	0	0	0

## АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>13,159,042.33</b>	<b>40,096,269.33</b>
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	00.00	00.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	00.00	00.00
33	<b>АВЛАГА</b>	00.00	00.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	00.00
335	<b>Бусад авлага</b>	00.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	00.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	00.00	00.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>13,159,042.33</b>	<b>40,096,269.33</b>
354	<b>Хангамжийн материал</b>	<b>9,898,042.33</b>	<b>26,356,269.33</b>
35410	Бичиг хэргийн материал	1,518,780.00	4,065,480.00
35420	Аж ахуйн материал	7,330,290.33	13,114,875.33
35430	Сэлбэг хэрэгсэл	599,000.00	554,000.00
35440	Түлш, шатах тослох материал	449,972.00	5,642,914.00
35470	Бусад хангамжийн материал	00.00	2,979,000.00
35600	Мал амьтад	3,261,000.00	13,740,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>393,582,630.85</b>	<b>430,984,217.14</b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>393,582,630.85</b>	<b>430,984,217.14</b>
392	<b>Биет хөрөнгө</b>	<b>266,289,130.85</b>	<b>303,452,383.78</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	191,838,060.00	191,838,060.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-11,580,283.28	-14,709,069.92
39203	Авто-тээврийн хэрэгсэл	132,200,000.00	122,200,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-90,056,666.71	-90,816,666.75
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	50,159,437.44	91,353,963.44
39206	Хуримтлагдсан элэгдэл	-22,717,414.10	-29,097,775.73
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	36,454,528.19	54,091,896.99
39208	Хуримтлагдсан элэгдэл	-20,224,530.69	-21,624,024.25
39217	Ном	216,000.00	216,000.00
393	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>127,293,500.00</b>	<b>127,531,833.36</b>
39301	Програм хангамж	550,000.00	825,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-550,000.00	-586,666.64
39303	Бусад биет бус хөрөнгө	127,293,500.00	127,293,500.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>406,741,673.18</b>	<b>471,080,486.47</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
41	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	00.00	00.00
413	<b>Өглөг</b>	00.00	00.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	00.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	00.00	00.00
4136	<b>Бусад өглөг</b>	00.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	00.00	00.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	00.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>406,521,673.18</b>	<b>471,080,486.47</b>
51	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	406,521,673.18	470,860,486.47
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	307,601,876.75	307,601,876.75
51101	Өмч: - төрийн	307,601,876.75	307,601,876.75
512	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>-92,993,523.57</b>	<b>-28,434,710.28</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-92,993,523.57	-92,773,523.57
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	64,338,813.29
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	191,913,320.00	191,913,320.00
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>406,521,673.18</b>	<b>471,080,486.47</b>

## АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>489,335,638.75</b>	<b>750,017,230.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>21,022,738.75</b>	<b>53,422,930.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>21,022,738.75</b>	<b>53,422,930.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	21,022,738.75	53,422,930.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	21,022,738.75	53,422,930.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>468,312,900.00</b>	<b>696,594,300.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>467,312,900.00</b>	<b>696,594,300.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	467,312,900.00	696,594,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>1,000,000.00</b>	<b>00.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,гүүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	00.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>480,615,358.89</b>	<b>688,939,416.71</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>480,615,358.89</b>	<b>688,939,416.71</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>473,230,207.69</b>	<b>665,147,890.81</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>343,204,086.00</b>	<b>483,164,778.81</b>
210101	Үндсэн цалин	343,204,086.00	429,468,387.81
210102	Нэмэгдэл	00.00	49,275,767.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	4,420,624.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>43,944,799.12</b>	<b>61,634,603.53</b>
210201	Тэтгэврийн даатгал	30,220,246.12	43,606,764.42
210202	Тэтгэмжийн даатгал	3,432,039.00	3,944,982.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,745,633.00	2,746,937.00
210204	Ажилгүйдлийн даатгал	682,798.00	682,449.30
210205	Эрүүл мэндийн даатгал	6,864,083.00	10,653,470.81
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>16,911,555.00</b>	<b>17,081,566.96</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,232,236.00	2,817,666.96
210302	Түлш, халаалт	12,920,600.00	13,843,500.00
210303	Цэвэр, бохир ус	758,719.00	420,400.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>26,146,993.82</b>	<b>27,938,933.80</b>
210401	Бичиг хэрэг	8,533,980.00	12,816,770.00
210402	Тээвэр, шатахуун	7,221,147.82	4,966,801.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,850,148.00	2,578,620.80
210404	Ном, хэвлэл	39,900.00	330,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,652,330.00	660,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,849,488.00	4,861,742.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	1,725,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>654,750.00</b>	<b>840,000.00</b>
210502	Хоол, хүнс	189,000.00	840,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	465,750.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>6,709,710.00</b>	<b>10,101,500.00</b>
210602	Тавилга	00.00	20,000.00
210604	Урсгал засвар	6,709,710.00	10,081,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,709,000.00</b>	<b>1,226,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,709,000.00	1,226,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>3,029,734.00</b>	<b>13,116,637.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,382,120.00	11,049,448.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	561,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,103,425.00	961,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	176,189.00	191,989.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	231,000.00
210807	Газрын төлбөр	00.00	100,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>30,919,579.75</b>	<b>50,043,870.71</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,610,500.00	14,456,562.20
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,170,000.00	8,468,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	21,139,079.75	27,119,308.51
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>7,385,151.20</b>	<b>23,791,525.90</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1,765,000.00</b>	<b>480,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,765,000.00	480,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>5,620,151.20</b>	<b>23,311,525.90</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,620,151.20	23,311,525.90
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>8,720,279.86</b>	<b>61,077,813.29</b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	<b>1,560,000.00</b>	<b>3,261,000.00</b>
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	1,560,000.00	3,261,000.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>1,560,000.00</b>	<b>3,261,000.00</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>10,280,279.86</b>	<b>64,338,813.29</b>

## АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>468,357,020.00</b>	<b>696,594,300.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>468,312,900.00</b>	<b>696,594,300.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	467,312,900.00	696,594,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	467,312,900.00	696,594,300.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	1,000,000.00	00.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	00.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>462,188,200.00</b>	<b>669,146,993.20</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>462,188,200.00</b>	<b>669,146,993.20</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>454,803,048.80</b>	<b>645,355,467.30</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	343,742,932.48	483,170,047.04
210101	Үндсэн цалин	263,299,002.56	310,105,023.81
210102	Нэмэгдэл	73,636,087.92	147,353,046.13
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,807,842.00	25,711,977.10
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	42,998,232.16	61,629,335.30
210201	Тэтгэврийн даатгал	29,276,232.16	44,308,808.88
210202	Тэтгэмжийн даатгал	3,430,500.00	4,083,852.57
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,744,400.00	3,325,082.11
210204	Ажилгүйдлийн даатгал	686,100.00	835,492.02
210205	Эрүүл мэндийн даатгал	6,861,000.00	9,076,099.72
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	16,911,555.00	16,916,566.96
210301	Гэрэл, цахилгаан	3,232,236.00	2,652,666.96
210302	Түлш, халаалт	12,920,600.00	13,843,500.00
210303	Цэвэр, бохир ус	758,719.00	420,400.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	27,834,597.16	37,445,303.80
210401	Бичиг хэрэг	9,144,600.00	14,341,660.00
210402	Тээвэр, шатахуун	8,719,999.16	9,478,401.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,751,398.00	2,578,620.80
210404	Ном, хэвлэл	132,400.00	742,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,637,500.00	710,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,448,700.00	9,594,622.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	565,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	565,000.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	7,469,998.00	11,914,450.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	70,000.00	160,000.00
210602	Тавилга	00.00	20,000.00
210604	Урсгал засвар	7,399,998.00	11,734,450.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,709,000.00	986,000.00
210702	Дотоод албан томилолт	1,709,000.00	986,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	8,101,734.00	15,631,237.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,454,120.00	13,612,037.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	540,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,103,425.00	961,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	176,189.00	165,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	231,000.00
210807	Газрын төлбөр	00.00	100,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	5,470,000.00	17,662,527.20
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,300,000.00	8,937,527.20
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,170,000.00	8,725,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>7,385,151.20</b>	<b>23,791,525.90</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,765,000.00	480,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,765,000.00	480,000.00

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,620,151.20	23,311,525.90
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,620,151.20	23,311,525.90
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>6,168,820.00</u>	<u>27,447,306.80</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	<u>6,124,700.00</u>	<u>27,447,306.80</u>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	<u>6,124,700.00</u>	<u>27,447,306.80</u>
2200	Дотоод эх үүсвэрээр	6,124,700.00	27,447,306.80
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6,124,700.00	27,447,306.80
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-6,124,700.00</u>	<u>-27,447,306.80</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	44,120.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

## АУДИТ ХИЙГДСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	307,601,876.75	192,220,088.60	-160,050,792.61	339,771,172.74
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	86,768.60	86,768.60
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>307,601,876.75</b>	<b>192,220,088.60</b>	<b>-159,964,024.01</b>	339,857,941.34
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	58,075,299.69	58,075,299.69
C08	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>307,601,876.75</b>	<b>191,913,320.00</b>	<b>-92,993,523.57</b>	406,521,673.18
D01	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>307,601,876.75</b>	<b>191,913,320.00</b>	<b>-92,993,523.57</b>	406,521,673.18
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	220,000.00	220,000.00
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>307,601,876.75</b>	<b>191,913,320.00</b>	<b>-92,773,523.57</b>	406,741,673.18
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00		00.00	
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	64,338,813.29	64,338,813.29
D09	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>307,601,876.75</b>	<b>191,693,320.00</b>	<b>-28,434,710.28</b>	<b>471,080,486.47</b>

## АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	/ төгрөгөөр /	
		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	696,594,300.00	673,282,774.10
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	696,594,300.00	673,282,774.10
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	696,094,300.00	672,802,774.10
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	504,404,200.00	483,170,047.04
210101	Үндсэн цалин	314,252,900.00	310,105,023.81
210102	Нэмэгдэл	162,391,500.00	147,353,046.13
210103	Унаа хоолны хөнгөлөлт	27,759,800.00	25,711,977.10
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	63,399,500.00	61,629,335.30
210201	Тэтгэврийн даатгал	45,047,200.00	44,308,808.88
210202	Тэтгэмжийн даатгал	4,588,100.00	4,083,852.57
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,670,500.00	3,325,082.11
210204	Ажилгүйдлийн даатгал	917,600.00	835,492.02
210205	Эрүүл мэндийн даатгал	9,176,100.00	9,076,099.72
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	17,073,700.00	16,916,566.96
210301	Гэрэл, цахилгаан	2,730,200.00	2,652,666.96
210302	Түлш, халаалт	13,943,500.00	13,843,500.00
210303	Цэвэр, бохир ус	400,000.00	420,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	37,451,700.00	37,445,303.80
210401	Бичиг хэрэг	13,662,500.00	14,341,660.00
210402	Тээвэр, шатахуун	9,480,000.00	9,478,401.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,000,000.00	2,578,620.80
210404	Ном, хэвлэл	409,200.00	742,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,000,000.00	710,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,900,000.00	9,594,622.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	36,736,000.00	36,724,388.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,000,000.00	8,999,938.00
210602	Тавилга	16,000,000.00	15,990,000.00
210604	Урсгал засвар	11,736,000.00	11,734,450.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,000,000.00	986,000.00
210702	Дотоод албан томилолт	1,000,000.00	986,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	15,729,200.00	15,631,237.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,710,000.00	13,612,037.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	540,000.00	540,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	961,200.00	961,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	165,000.00	165,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	231,000.00	231,000.00
210807	Газрын төлбөр	100,000.00	100,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	20,300,000.00	20,299,896.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,300,000.00	11,299,896.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,000,000.00	9,000,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	500000.00	480000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	500,000.00	480,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	480,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	696,594,300.00	673,282,774.10
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	696,594,300.00	673,282,774.10
131001	Улсын төсвөөс санхүүжих	696,594,300.00	673,282,774.10
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	22.00	21.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	10.00	10.00
620003	Үйлчлэх ажилтан	11.00	10.00